



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Ховд аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ХОА-2022/10/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Ховд хот
2023 он

Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар
Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn
Аудитын менежер: А.Цэцэгсүрэн
Утас: 70432545
Цахим хаяг: tsetsegsuren.a@audit.gov.mn
Ахлах аудитор: Д.Нарантуул
Утас: 99019800
цахим хаяг: Oyunjargals@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

**ХОВД АЙМГИЙН ХҮНС ХӨДӨӨ
АЖ АХУЙН ГАЗРЫН ДАРГА
Б.БЯМБАЖАВ ТАНАА**

2023.02.20 № 2/62
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Ховд аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Ховд аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Эргэлтийн хөрөнгө 211.5 сая төгрөгөөр нэмэгдэхэд тус байгууллага хүлээж аваагүй ХХААЯ, ХААД сангаас ирсэн бараа материалыг бүртгээж тайлагнасан нь нөлөөлсөн байна.

Аудитын гол асуудал

Удаан жилийн насжилттай өндөр дүнтэй авлага өр төлбөрийг барагдуулах чиглэлээр Баялаг буянт ХХК-аас 15.7 сая, Алтай номадис ХХК-аас 1.7 сая төгрөгийг төлүүлэн авлага нийт 17.2 сая төгрөгөөр буурсан байна

Бусад асуудлын хэсэг

2022 онд 4 зорилт 70 арга хэмжээг хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулан батлуулж, биелэлтийг тооцон төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлжээ.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

021020154

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ХҮНДЭТГЭСЭН: ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:



Х.БОЛДБААТАР

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	11
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	11
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	12
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд.....	12
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	13
3.5.1 Төсвийн төлөвлөлт	13
3.5.2 Төсвийн гүйцэтгэл	13
3.5.3 Нэмэлт төсөв	13
4. АУДИТЫН ТАЙЛАН	13
4.1 Ерөнхий зүйл	13
4.2 Материаллаг байдал	14
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	14
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	14
4.5 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн	15
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	15
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	15
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	16

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ХХААХҮЯ	Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яам
ХХААД	Хүнс хөдөө аж ахуйн дэмжих
ТШЗ	Төсвийн шууд захирагч

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/ төгрөгөөр /

Давсны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>586,570,133.12</u>	<u>798,066,987.37</u>
33	АВЛАГА	543,504,654.00	515,530,671.74
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	170,000.00	1,132,847.69
33300	Татаас, санхүүжилтийн авлага	-	8,694,593.00
335	Бусад авлага	543,334,654.00	505,703,231.05
3351	Байгууллагаас авах авлага	543,334,654.00	505,703,231.05
34	УРЬДЧИЛГАА	7,200,000.00	-
34600	Урьдчилж гарсан зардал	7,200,000.00	-
35	БАРАА МАТЕРИАЛ	35,865,479.12	282,536,315.63
351	Түүхий эд материал	304,000.00	304,000.00
35110	Тусгай зориулалттай материал	304,000.00	304,000.00
354	Хангамжийн материал	22,762,479.12	252,452,315.63
35410	Бичиг хэргийн материал	1,169,328.70	760,528.70
35420	Аж ахуйн материал	13,853,048.02	38,922,211.42
35430	Сэлбэг хэрэгсэл	286,000.00	286,000.00
35440	Түлш, шатах тослох материал	1,102,000.00	4,000,000.00
35470	Бусад хангамжийн материал	6,352,102.40	208,483,575.51
35600	Мал амьтад	12,799,000.00	29,780,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>459,597,627.84</u>	<u>402,326,035.20</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	459,597,627.84	402,326,035.20
392	Биет хөрөнгө	350,865,377.88	297,061,235.28
39201	Барилга, байгууламж, орон сууц	86,060,080.00	86,060,080.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(2,868,669.60)	(4,303,004.40)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	254,453,527.00	254,453,527.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(161,322,927.30)	(183,314,946.76)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	117,955,635.43	49,741,898.62
39206	Хуримтлагдсан элэгдэл	(104,704,279.56)	(24,993,399.81)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	20,791,305.76	13,793,659.59
39208	Хуримтлагдсан элэгдэл	(14,443,680.24)	(9,361,908.72)
39214	Бусад үндсэн хөрөнгө	271,457,036.71	270,726,536.50
39215	Хуримтлагдсан элэгдэл	(116,512,650.32)	(155,741,206.74)
393	Биет бус хөрөнгө	108,732,249.96	105,264,799.92
39301	Програм хангамж	16,469,800.00	16,469,800.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(3,467,450.04)	(6,934,900.08)
39303	Бусад биет бус хөрөнгө	95,729,900.00	95,729,900.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,046,167,760.96</u>	<u>1,200,393,022.57</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,046,167,760.96</u>	<u>1,200,393,022.57</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	1,046,167,760.96	1,200,393,022.57
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,175,118,077.35	1,175,118,077.35
51101	Өмч: - төрийн	1,175,118,077.35	1,175,118,077.35

512	Хуримтлагдсан үр дүн	(218,268,951.28)	(64,043,689.67)
51210	Өмнөх үеийн үр дүн	(40,203,274.50)	(218,268,951.28)
51220	Тайлант үеийн үр дүн	(178,065,676.78)	154,225,261.61
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	89,318,634.89	89,318,634.89
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,046,167,760.96	1,200,393,022.57

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/ төгрөгөөр /

Даясны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	424,775,923.70	719,013,414.31
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	13,812,128.70	367,269,111.31
120	Нийтлэг татварын бус орлого	13,812,128.70	367,269,111.31
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	13,812,128.70	367,269,111.31
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	13,812,128.70	367,269,111.31
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	410,963,795.00	351,744,303.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	365,388,300.00	279,167,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	365,388,300.00	279,167,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	45,575,495.00	72,577,303.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	37,300,000.00	23,394,830.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	23,694,593.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	8,275,495.00	25,487,880.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	602,841,600.48	556,837,098.42
21	УРСГАЛ ЗАРДАЛ	602,841,600.48	556,837,098.42
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	517,234,089.48	522,728,356.88
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	191,898,756.00	213,892,403.46
210101	Үндсэн цалин	173,811,370.00	154,548,109.46
210102	Нэмэгдэл	16,360,714.00	41,863,294.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	1,726,672.00	3,924,060.00
210104	Урамшуулал	-	13,556,940.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	24,073,749.00	25,190,705.31
210201	Тэтгэврийн даатгал	16,998,305.37	16,948,582.61
210202	Тэтгэмжийн даатгал	1,887,427.40	2,127,224.42
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,509,942.25	1,559,526.87
210204	Ажилгүйдлийн даатгал	334,370.16	543,445.02
210205	Эрүүл мэндийн даатгал	3,343,703.82	4,011,926.39
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	10,170,893.00	10,046,287.00
210301	Гэрэл, цахилгаан	754,733.00	599,227.00
210302	Түлш, халаалт	9,416,160.00	9,447,060.00

2104	Хангамж, бараа материалын зардал	182,601,340.02	59,982,127.75
210401	Бичиг хэрэг	1,277,400.00	1,990,000.00
210402	Тээвэр, шатахуун	9,331,937.00	15,817,607.95
210403	Шуудан, холбоо, интернэгийн төлбөр	502,760.00	2,079,995.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	11,810,243.02	26,794,580.00
210408	Бараа материал акталсны зардал	679,000.00	13,299,944.80
210409	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн /ТӨҮГ/	159,000,000.00	-
2107	Томилолт, зочны зардал	1,188,000.00	434,930.00
210702	Дотоод албан томилолт	1,188,000.00	434,930.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	74,733,900.00	46,980,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	69,595,900.00	37,763,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	350,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	841,500.00	707,200.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	280,500.00	714,400.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	66,000.00	55,400.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,600,000.00	7,740,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	32,567,451.46	166,201,403.36
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,921,700.00	74,390,950.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	26,645,751.46	72,688,938.36
210904	Найдваргүй авлагын алдагдал	-	19,121,515.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	85,607,511.00	34,108,741.54
2132	Бусад урсгал шилжүүлэг	25,939,000.00	1,160,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	25,329,000.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	610,000.00	1,160,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	59,668,511.00	32,948,741.54
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	59,668,511.00	32,948,741.54
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(178,065,676.78)	162,176,315.89
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	7,951,054.28
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	857,054.28
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	-	7,094,000.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	(7,951,054.28)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(178,065,676.78)	154,225,261.61

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	423,413,795.00	368,944,303.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	423,413,795.00	368,944,303.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	365,388,300.00	279,167,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	365,388,300.00	279,167,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	58,025,495.00	89,777,303.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	37,300,000.00	23,394,830.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,650,000.00	23,694,593.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	15,075,495.00	42,687,880.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	423,413,795.00	368,944,303.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	423,413,795.00	368,944,303.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	337,806,284.00	326,140,968.46
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	193,192,299.00	213,722,403.46
210101	Үндсэн цалин	149,814,843.00	154,378,109.46
210102	Нэмэгдэл	35,372,652.00	41,863,294.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	8,004,804.00	3,924,060.00
210104	Урамшуулал	-	13,556,940.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	22,953,457.00	26,323,553.00
210201	Тэтгэврийн даатгал	16,210,013.80	18,081,430.30
210202	Тэтгэмжийн даатгал	1,804,449.09	2,127,224.42
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,443,559.14	1,559,526.87
210204	Ажилгүйдлийн даатгал	317,766.95	543,445.02
210205	Эрүүл мэндийн даатгал	3,177,668.02	4,011,926.39
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	10,468,893.00	11,055,287.00
210301	Гэрэл, цахилгаан	754,733.00	599,227.00
210302	Түлш, халаалт	9,416,160.00	9,447,060.00
210303	Цэвэр, бохир ус	298,000.00	1,009,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	5,390,260.00	10,142,795.00
210401	Бичиг хэрэг	492,300.00	1,897,100.00
210402	Тээвэр, шатахуун	3,956,800.00	5,868,700.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	576,860.00	2,079,995.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	364,300.00	297,000.00
2105	Нормативт зардал	181,200.00	141,700.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	181,200.00	141,700.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	261,400.00	204,300.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	175,000.00	136,700.00
210604	Урсгал засвар	86,400.00	67,600.00
2107	Томилдолт, зочны зардал	1,188,000.00	434,930.00
210702	Дотоод албан томилдолт	1,188,000.00	434,930.00

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	99,924,525.00	60,044,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	87,586,525.00	58,027,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	350,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	841,500.00	707,200.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	280,500.00	714,400.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	66,000.00	55,400.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	10,800,000.00	540,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,246,250.00	4,071,500.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,246,250.00	4,071,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	85,607,511.00	42,803,334.54
2132	Бусад урсгал шилжүүлэг	25,939,000.00	1,160,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	25,329,000.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	610,000.00	1,160,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	59,668,511.00	41,643,334.54
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	59,668,511.00	41,643,334.54
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,175,118,077.35	89,318,634.89	-41,478,274.62	1,222,958,437.62
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	1,275,000.12	1,275,000.12
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,175,118,077.35	89,318,634.89	-40,203,274.50	1,224,233,437.74
C07	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-178,065,676.78	-178,065,676.78
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,175,118,077.35	89,318,634.89	-218,268,951.28	1,046,167,760.96
D01	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,175,118,077.35	89,318,634.89	-218,268,951.28	1,046,167,760.96
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,175,118,077.35	89,318,634.89	-218,268,951.28	1,046,167,760.96
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	154,225,261.61	154,225,261.61
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,175,118,077.35	89,318,634.89	-64,043,689.67	1,200,393,022.57

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	279,167,000.00	276,581,068.46
21	УРСГАЛ ЗАРДАЛ	279,167,000.00	276,581,068.46
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	277,999,700.00	275,421,068.46
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	213,826,800.00	213,722,403.46
210101	Үндсэн цалин	157,443,100.00	154,378,109.46
210102	Нэмэгдэл	37,263,900.00	41,863,294.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,525,100.00	3,924,060.00
210104	Урамшуулал	13,594,700.00	13,556,940.00
2102	Нийгмийн даатгалд төлөх шимтгэл	27,015,900.00	26,323,553.00
210201	Тэтгэврийн даатгал	18,234,800.00	18,081,430.30
210202	Тэтгэмжийн даатгал	2,145,300.00	2,127,224.42
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,716,200.00	1,559,526.87
210204	Ажилгүйдлийн даатгал	629,100.00	543,445.02
210205	Эрүүл мэндийн даатгал	4,290,500.00	4,011,926.39
2103	Тогтмол зардал	12,688,600.00	11,055,287.00
210301	Гэрэл, цахилгаан	1,214,400.00	599,227.00
210302	Түлш, халаалт	10,022,100.00	9,447,060.00
210303	Цэвэр, бохир ус	1,452,100.00	1,009,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	10,234,000.00	10,142,795.00
210401	Бичиг хэрэг	1,897,300.00	1,897,100.00
210402	Тээвэр, шатахуун	5,868,700.00	5,868,700.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,170,900.00	2,079,995.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	297,100.00	297,000.00
2105	Нормативт зардал	141,700.00	141,700.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	141,700.00	141,700.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	204,300.00	204,300.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	136,700.00	136,700.00
210604	Урсгал засвар	67,600.00	67,600.00
2107	Томилолт, зочны зардал	485,800.00	434,930.00
210702	Дотоод албан томилолт	485,800.00	434,930.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,331,100.00	9,324,600.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,314,100.00	7,307,600.00
210803	Даатгалын үйлчилгээ	707,200.00	707,200.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	714,400.00	714,400.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	55,400.00	55,400.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	540,000.00	540,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,071,500.00	4,071,500.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,071,500.00	4,071,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,167,300.00	1,160,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,167,300.00	1,160,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,167,300.00	1,160,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	279,167,000.00	276,581,068.46
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	279,167,000.00	276,581,068.46
122005	Улсын төсвөөс	279,167,000.00	276,581,068.46
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	0.00	21.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	0.00	1.00
610001	Төсвийн байгууллага	0.00	1.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	0.00	20.00
620001	Удирдах ажилтан	0.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	0.00	15.00
620003	Үйлчлэх ажилтан	0.00	4.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	50,719,900.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	50,719,900.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	50,719,900.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	50,719,900.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	50,719,900.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	50,719,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	50,719,900.00
131103	ЗГНХ,ЗДНХөрсөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	23,394,830.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	23,694,593.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	3,630,477.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Ховд аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газар нь 2022 онд Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийн санхүүжилтийн хүртээмжийг нэмэгдүүлэх, орон нутгийн төсөвт тусган хэрэгжүүлэх гэсэн зорилт дэвшүүлэн 3 алба 20 албан хаагчтайгаар үйл ажиллагаагаа явуулж байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус байгууллага нь Жижиг дунд үйлдвэрлэл үйлчилгээ, хоршооны тухай хууль, Малын удмын сангийн тухай хууль, Хүнсний тухай хууль, Газар тариалангийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, хууль тогтоомжуудыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх Төрийн хэмнэлтийн тухай хууль баталж мөрдөж эхэлсэн байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Байгууллагын даргын тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг тус байгууллагын өмч хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавин ажиллаж байна.

2022 онд Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2022 оны 02 дугаар 22-ны өдрийн 64 дүгээр тогтоолын дагуу Хүнс хөдөө аж ахуйн газрын даргын 2022 оны 05 дугаар сарын 09-ны А/09 дүгээр тушаалаар төрийн болон орон нутгийн өмчийн улсын үзлэг, тооллогын ажлыг зохион байгуулах ажлын хэсэг 5 хүний бүрэлдэхүүнтэйгээр томилж, тооллогыг зохион байгуулж хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, бүрэн бүтэн байдалд хяналт тавих ажлуудыг зохион байгуулсан байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хүнс, хөдөө аж ахуйн газар нь 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Ховд аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар нь 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 153.1 сая төгрөгөөр буюу 15.0 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/сая. төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	543.5	514.4	(36.1)
Бараа материал	35.9	282.5	246.6
Үндсэн хөрөнгө	459.6	402.2	(57.4)
Нийт хөрөнгө	1046.16	1199.26	153.10
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1046.16	1199.26	153.10
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1046.16	1199.26	153.10

Дээрх хүснэгтээс харахад Ховд аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газрын 2022 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 153.10 сая төгрөгөөр өссөний материаллаг нөлөө нь мөнгөн хөрөнгө, бараа материал, үндсэн хөрөнгийн данстай холбоотой байна.

Дансны үлдэгдэлд гарсан дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- ✓ Авлагын данс “Баялаг Буянт”-аас 468.3 сая, Алтайн номадис ХХК -аас 33.4 сая, “НИК ХХК”-аас 4.0 сая, Татаас санхүүжилтийн авлага 8.6 сая төгрөгийн үлдэгдэлтэй

байна. Авлага 36.1 төгрөгөөр буурсан нь байгууллагаас авах авлага буурсантай холбоотой.

- ✓ Бараа материалын данс 246.6 сая төгрөгөөр өссөн нь ХХААЯ, ХААДСангаас үр , багаж хэрэгсэл, зөөврийн усан сан бүртгэсэнтэй холбоотой байна.
- ✓ Үндсэн хөрөнгө 57.4 сая төгрөгөөр буурсан нь үндсэн хөрөнгө акталж данснаас хассан , элэгдлийн зардалтай холбөөтэй байна.
- ✓ Цэвэр хөрөнгө 153.10 сая төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 279.2 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлэн батлагдсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд улсын төсвөөс 279.2 сая төгрөгөөр санхүүжиж 276.6 сая төгрөгийн зардал гарган, оны эцэст 2.6 сая төгрөгийн төсвийг хэмнэж улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл нь 276.6 сая төгрөг буюу 99 хувьтай байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

Код	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/сая төгрөг/	
				Зөрүү	Биелэлт
80101	Үндсэн үйл ажиллагаа	278.0	275.4	2.6	99%
80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	1.2	1.2	0.0	100%
	дүн	279.2	276.6	2.6	99 %

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар ЗД-ын А/602 захирамж, 4,8 хөтөлбөр Намрын ногоон өдрүүд Үндэсний үйлдвэрлэл, 2022 нэгдсэн арга ХХААХҮЯам 89.7 сая төгрөг ирснийг зориулалтын дагуу зарцуулж 39.1 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу

Ховд аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг ахлах аудитор Д.Нарантуул гэрээт аудитор М.Энхжаргал нар 2023 оны 02 дугаар сарын 15-ний өдрөөс 02 дүгээр сарын 20-ны хооронд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер А.Цэцэгсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Х.Болдбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Тус байгууллага нь 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн 22 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны орлого үр дүнгийн тайлангийн нийт зардлын 557.9 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 8.3 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 6.7 сая төгрөгөөр тогтоосон.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага хуулиар хориглосон зардлуудыг санхүүжүүлээгүй байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим системд таван саяас дээш орлогын гүйлгээг мэдээлээгүй, байсныг аудитын явцад залруулан мэдээлүүллээ.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8.төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх, “Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5.дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалттай нийцүүлж, 2012 оноос хойш он дамжин нэр зөрүүтэй бүртгэгдсэн 19121.5 мянган төгрөгийн төвлөрүүлэх шилжүүлгийн авлагыг ХХААХҮЯ-тай тооцоо нийлж баталгаажуулах, гэрээний дагуу авлагын барагдуулалтад хяналт тавих гэсэн зөвлөмж өгснийг хэрэгжүүлэн ажилласан байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

ХААДСангаас 200.9 сая төгрөгийн зөөврийн усан сан, хадуур, үр үрлэгч, хүнсний ногоо ухагч, хүлэмж төмсний мотоблок цаг уурын бичил станц зэрэг газар тариалангийн зориулалтын тоног төхөөрөмжүүдийн олголт, буцаан төлөлтийг нягтлан хянах шаардлагатай байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 1.1 сая төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 1.1 сая төгрөгийн алдааг залруулав.

Үүнд:

- ✓ **Хууль тогтоомжтой холбоотой:** Нийгмийн даатгалын НД-7Б маягтаар 1.1 сая төгрөгийн авлагатай тайлагнасан ч санхүүгийн тайланд тусгаагүй нь Төсвийн тухай хуулийн 6-р зүйлийн 6.4.1-д төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах 6-р зүйлийн 6.4.8-д төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.
- ✓ 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын гүйлгээ, төсвийн хөрөнгө зарцуулахтай холбоотой гарсан шийдвэр, тендер худалдан авалтын мэдээллийг аудитын явцад нөхөн тайлагнуулж тус тус залрууллаа

Аудитаар нийт 200.9 сая төгрөгийн зөрчил² илэрснээс, зөрчлийг арилгах 200.9 сая төгрөгийн 2 зөвлөмж өглөө.

5.1 Зөвлөмж

5.1.1 Бараа материалтай холбоотой

Илрүүлэлт: ХААДСангаас 200.9 сая төгрөгийн зөөврийн усан сан, хадуур, үр үрлэгч, хүнсний ногоо ухагч, хүлэмж төмсний мотоблок цаг уурын бичил станц зэрэг газар тариалангийн зориулалтын тоног төхөөрөмжүүдийг аймгийн Засаг даргын тамгын газраар дамжуулан иргэдэд олгосон, дээрх эргэлтийг хөрөнгийг аймгийн ХХААГ-т хүлээлгэн өгөөгүйг нягтлан бодогч нь санхүүгийн тайланд бараа материалд бүртгэсэн байна.

Өгсөн зөвлөмж : Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8.төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх, “Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20-р зүйлийн 2.6 эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах гэсэн заалттай нийцүүлж, ХААДС-аас ирсэн 200.9 сая төгрөгийн бараа материалын дансанд бүртгэгдсэн тоног төхөөрөмжийг ХХААХҮЯ, Аймгийн ЗДТГ-тай тооцоо нийлж асуудлыг шийдвэрлэх

5.1.2 Цалингийн зардалтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Байгууллагын албан хаагчдад улирал бүр ажлын үр дүнг тооцож дүгнээгүй, жилийн эцэст бөөн дүнгээр урамшуулалт цалин олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.4.2, Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1.4, МУЗГ-ын 2019 оны 5 дугаар тогтоолуудтай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.4.2, Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1.4, МУЗГ-ын 2019 оны 5 дугаар тогтоолын дагуу улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулалд шаардагдах хөрөнгийг төсөвт батлуулж тухай бүр олгож байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая.төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруул аагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Бүртгээгүй байсан авлагыг бүртгүүлсэн	1	1.1			1	1.1	1	1.1				
Шилэн дансанд мэдээлэл байршуулаагүй	1						1					
Дүн	2	1,1			1	1,1	2	1,1	0	0	0	0

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/ сая төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлаг а тооцуулах албан шаардлаг а		Хууль, хяналты н байгуулл агад нилжүүп сэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бараа материалыг үнэн зөв бодиттой бүртгэх	1	200.9					1	200.9			-	-
Үр дүнгийн нэмэгдэл тооцож олгоогүй, оны эцэст бөөн дүнгээр олгосон	1	0					1				-	-
Дүн	2	200.9					2	200.9			-	-

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:  Х.БОЛДБААТАР

АУДИТЫН МЕНЕЖЕР:  А.ЦЭЦЭГСҮРЭН

ТАЙЛАНГ БИЧСЭН:

АХЛАХ АУДИТОР  Д.НАРАНТУУЛ

ГЭРЭЭТ АУДИТОР:  М.ЭНХЖАРГАЛ